



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 07 сарын 24 өдөр

Дугаар А/359

Ховд

Улсын комисс байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.4-ийн "а", Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6 дахь заалт, Засгийн газрын 2018 оны 317 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар баригдсан Ховд аймгийн Жаргалант сумын Рашаант багийн инженерийн хийцтэй ухаалаг худаг гаргах ажлыг хүлээн авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

Б.Баярсүх

- Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга

Гишүүд: Б.Туулайтулга

- Жаргалант сумын Засаг даргын орлогч

М.Цогт-Эрдэнэ

- Хүнс, хөдөө аж ахуйн газрын мэргэжилтэн

Тогтохбаяр

- Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Барилга хот байгуулалтын хэлтсийн ахлах мэргэжилтэн

Т.Бямбажаргал

- Байгаль орчны газрын усны асуудал хариуцсан мэргэжилтэн

Н.Ганбат

- Аймгийн Иргэдийн Хурлын Төлөөлөгч

З.Уянга

- Жаргалант сумын Засаг даргын Тамгын газрын Хөдөө аж ахуйн мэргэжилтэн

Г.Цэлмэг

- Рашаант багийн Засаг дарга

Б.Түмэнжаргал

- Орон нутгийн өмчиний газрын мэргэжилтэн

Ж.Дамбарэнцэн

- "Эвлэл" ХХК-ийн захирал


Нарийн бичгийн
дарга: Г.Билгүүн

- Аймгийн Засаг даргын дэргэдэх зөвлөх
багийн гишүүн

2. Инженерийн хийцтэй ухаалаг худгийн гүйцэтгэл, бичиг баримтыг шалган санхүүжилтийг олгохыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/, Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга /Б.Баярсүх/ нарт зөвшөөрсүгэй.

3. Тухайн ажлын даалгавар, зураг төсөвтэй тулган шалгаж, норм нормативыг баримт бичигт заасан техникийн үзүүлэлт, шаардлагын дагуу гүйцэтгэсэн эсэхийг хянан баталгаажуулж, шийдвэр гаргахыг Улсын комиссын дарга /Б.Баярсүх/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ